

## АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨМЖ (2013 он)

**Зөвлөмж 201303/01.** Агаарын тээврийн компаниудын нисгэх багийн давтан сургалтыг зохион байгуулдаг гадаад улсын нислэгийн дадлагажуурын байгууллагуудыг дахин баталгаажуулж сургалтын чанарыг сайжруулах арга хэмжээ авах.

**Зөвлөмж 201303/02.** SAAB340 агаарын хөлгийн нисгэх багийн давтан сургалтыг хангалтгүй зохион байгуулж байгаа Pan Am International Flight Academy-ын баталгаажуулалтыг цуцалж тус байгууллагын дадлагажуурт нисгэх багийг сургахгүй байх

**Зөвлөмж 201303/03.** Агаарын тээврийн компаниудын нисгэх багийн давтан сургалтын хөтөлбөр өөр өөр байгааг нэг стандарт шаардлагад оруулах.

**Зөвлөмж 201303/04** .МИАТ ХК-аас нислэгийн дадлагажуурт хийгдэх давтан сургалтыг 2 удаагийн дадлага авсны дараа шалгалт /SIM-SIM-OPC/өгч байхаар зохион байгуулагдсан байхад бусад агаарын тээвэрлэгчид 1 удаа дадлага авсны дараа шалгалт /SIM-OPC/ өгч байгаа тул симулятор сургалтын хамгийн бага байх дадлагын давтамжийг тогтоох, нисгэх багийн ур чадварын болон бусад түвшингээс хамааруулж дадлагын давтамжийг тогтоох, нисгэх багийн ур чадварын болон бусад түвшингээс хамааруулж дадлагын давтамжийг нэмэгдүүлж байх нэгдсэн тогтолцоонд оруулах.

**Зөвлөмж 201303/05.** Нислэгийн дадлагажуурт давтан сургалтын дараа хийгдэх компаний ур чадварын шалгалт /Operator Proficiency Check/-ийг агаарын тээвэрлэгч компаниас зохион байгуулах, шалгалтыг чанаржуулж компанийн үнэлэлт, дүгнэлтийг өгч байх.

**Зөвлөмж 201303/06.** Нисгэгчийн үнэмлэх сунгалтын өмнөх /Operator Proficiency Check/ болон / Proficiency Check/- ын шалгалтыг шинэчлэн зохион байгуулж шалгалтын үр дүнг нисгэх багийн ур чадварт үнэлэлт, дүгнэлт өгөх, үнэмлэхний хугацааг сунгах шаардлагад хамруулж байх.

**Зөвлөмж 201303/07.** Нислэгийн ашиглалтын заавар нь англи хэл дээр байгаа агаарын хөлөгт багшлах, багш нисгэгчийн англи хэлний түвшингийн шаардлагад ИКАО-ын мэргэжлийн түвшин /operational level/- ийн стандартыг ашиглах.

**Зөвлөмж 201304/08.** Агаарын тээврийн МИАТ ХК-ийн B737-800 агаарын хөлөгт ашиглагдаж байгаа бүх дугуйны үндсэн хэсэг /wheel hub/-д сорилын үзлэгүүдийг хийж дүгнэлт гаргах.

**Зөвлөмж 201304/09.** Агаарын тээврийн МИАТ ХК-ийн В737-800 агаарын хөлөгт ашиглагдаж байгаа 2005 оноос өмнөх дугуйны үндсэн хэсэг /wheel hub/-ийг нислэгт ашиглахгүй байх.

**Зөвлөмж 201304/10.** Дугуйны үндсэн эд анги нь /HUB/-д сорилын Хувьсах гүйдлийн тест /eddy current test/, Хэт авианы тест / ultra-sonic test /-ээр хийх үзлэгийн ажлыг сайжруулах, сургалт дадлагын ажлыг хийлгэх.

**Зөвлөмж 201304/11.** Honeywell-ийн үйлдвэрлэгчээс гаргасан SB2612 311-32-103 бюллетенийн дагуу В737-800 агаарын хөлгийн дугуйны үндсэн хэсэг /wheel hub/-д хийх үзлэгийн давтамж, хугацааг тогтоож үзлэг хийж байх

**Зөвлөмж 201304/12.** Чингис хаан нисэх буудлын үндсэн зурвасны эхэнд RWY32 талаас 500 метрт хуучин гадаргуу нэмэлт хучилтын гадаргууны залгаасыг засварлах, уг хэсгийн нэмэлт хучилтыг хийж дуусгах.

#### **Зөвлөмж 201304/13**

Чингис хаан нисэх буудлын агаарын хөлгийн хөөрч буух зурвас, явгалах зам, зогсоолуудад гадны эд анги байгаа эсэхэд нарийвчилсан үзлэг шалгалтыг хийж, холбогдох арга хэмжээг авахыг ИНЕГ, Чингис хаан нисэх буудлын захиргаанд

**Зөвлөмж 201304/14.** В737-800, EI-CSG агаарын хөлгийн дугуйнд үүссэн гэмтлийн нөхцөл байдлыг Солонгос улсын Инчон нисэх буудлын холбогдох газарт нэн даруй мэдээлэл хүргүүлэхийг МИАТ ХК-д

**Зөвлөмж 201304/15.** Агаарын хөлгийн засвар үйлчилгээний газрын онгоцны зогсоол талбайд гадны эд анги байгаа эсэхэд нарийвчилсан үзлэг шалгалт хийх, нислэгийн өмнөх болон өдрийн үзлэг үйлчилгээг чанартай хийлгэх болон болсон байдлыг инженер техникийн бүрэлдэхүүнд танилцуулах арга хэмжээ авахыг МИАТ ХК-д.

**Зөвлөмж 201308/16.** Иргэний нисэхийн ерөнхий газар Монгол, Хятадын хилийн дэглэмийн тухай Монгол Улсын засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын 2010 оны 6 дугаар сарын 10-д байгуулсан гэрээний дагуу Хятад, Монголын хилийн орчимд хилийн шугамаас өөрийн тал руу 25 км-ийн бүс дотор агаараас зураг авах, хэмжилт хийх, агаарын хөлөг нислэг үйлдэх тохиолдолд эрх бүхий байгууллагаас дипломат шугамаар Хятадын талд мэдэгдсэн мэдэгдлээс хойш 15-аас доошгүй хоногийн дараа нислэг үйлдэх зөвшөөрлийг олгож байх.

**Зөвлөмж 201308/17.** Иргэний нисэхийн ерөнхий газар хилийн бүс орчимд нислэг үйлдэхтэй холбогдсон харилцааг зохицуулах дүрэм, зааврыг Монгол улсын хууль, хөрш орнуудтай хийсэн гэрээ хэлцэл, бусад эрх зүйн баримт бичигт нийцүүлэн боловсруулан мөрдөж ажиллах.

**Зөвлөмж 201308/18.** Иргэний нисэхийн ерөнхий газар “Нисгэгчийн мэргэжлийн үнэмлэх, зэрэглэл хүсэх өргөдөл”-ийн батлагдсан маягтыг бүрэн дүүрэн ашиглах, үнэмлэх гэрчилгээжүүлэлттэй холбогдсон ажлын зохион байгуулалтыг сайжруулах.

**Зөвлөмж 201308/19.** Томас Эйр ХХК нь дүгнэлтэд заагдсан эрх зүйн акт (ИНД95.57 ба 95.59-р заалт, ИНД135.55-р заалт, ИНД12.55-ын (б) заалт “Нислэгийн хөдөлгөөнийг төлөвлөх, зөвшөөрөл олгох журам”-ын 4.13-р заалт ICAO-гийн doc 4444-ийн А2-1-шаардлага)-ын заалтыг “General Operations Manual”-д тусгаж хэрэгжүүлж ажиллах.

**Зөвлөмж 201308/20.** Агаарын зайн зохион байгуулалт, холбоо навигаци ажиглалтын тоног төхөөрөмжийн сонголт, байршуулалт, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны заавар, технологийг өөрийн онцлог болон иргэний нисэхийн олон улсын байгууллагын баримт бичгийн холбогдох заалтуудтай уялдуулан боловсронгуй болгох арга хэмжээг тасралтгүй авч байх үүрэг бүхий судалгааны нэгж бий болгож ажиллуулах.

**Зөвлөмж 201308/21.** Автомат удирдлагын Aircon2100 системийн SDD-г нислэгийн хөдөлгөөний үйлчилгээнд ашиглах техникийн нөхцөлийг тодорхойлж, SDD-UM –д тусгаж, холбогдох бие бүрэлдэхүүнд судлуулах.

**Зөвлөмж 201308/22.** Секторын үйл ажиллагааны зааварт нислэгийн хөдөлгөөний үйлчилгээг радиолокаторын аргачиллаас процедурын, процедурын аргачиллаас радиолокаторын аргачлалд шилжүүлэх үед нислэгийн удирдагч нарын гүйцэтгэх үүргийг нарийн тогтоож өгөх.

**Зөвлөмж 201308/23.** Дотоод гадаад 3-10 сарын мэргэшүүлэх сургалтанд түр курсээр бэлтгэгдсэн нислэгийн удирдагч нарт нисэхийн анхан шатны мэргэжил олгох сургалт зохион байгуулах.